



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/129

Улаанбаатар хот

Бүрэлдэхүүн сургуулиудын элсэлтийн болон
шинэ элсэгчид тэтгэлэг олгох журам
батлах тухай

Монгол Улсын "Дээд боловсролын тухай хууль", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/143 тоот тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам", СЭЗИС-ийн элсэлтийн нэгдсэн бодлогод үндэслэн ТУШААХ нь:

1. "Санхүү эдийн засгийн их сургуулийн Бүрэлдэхүүн сургуулиудын бакалаврын хөтөлбөрт 2025-2026 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Бүрэлдэхүүн сургуулиудын шинэ элсэгчид тэтгэлэг олгох журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан элсэлтийн үйл ажиллагааны нэгдсэн зохион байгуулалт, удирдлагаар хангаж ажиллахыг Бүрэлдэхүүн сургуулиудын элсэлтийн комиссын дарга (Д.Оюунсүрэн ХСХЭрхлэгч), Нарийн бичгийн дарга (Г.Сарангэрэл НШУС-ийн Тэнхмийн эрхлэгч) нарт, Бүрэлдэхүүн сургуулиудын элсэлтийн системийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг (Б.Тулга ИТС-ийн захирал) нарт даалгасугай.

3. 2025-2026 оны хичээлийн жилд оюутан элсүүлэхтэй холбоотой журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг бүрэлдэхүүн сургуулийн элсэлтийн комиссын дарга (Д.Оюунсүрэн ХСХЭрхлэгч)-д, холбогдох зардлыг төсвөөс зарцуулахыг Бүрэлдэхүүн сургуулиудын нягтлан бодогч (Б.Мөнхтуул)-д зөвшөөрсүгэй.

РЕКТОР



Б.МӨНХБАЯР



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИУДЫН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ 2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Санхүү Эдийн Засгийн Их Сургууль (цаашид СЭЗИС гэх)-ийн бүрэлдэхүүн Нийгмийн шинжлэх ухааны сургууль, Инженер, Технологийн сургууль, Боловсролын сургууль (Цаашид СЭЗИС-ийн Бүрэлдэхүүн сургуулиуд гэх)-ийн бакалаврын үндсэн болон олон улсын хамтарсан хөтөлбөрт 2025-2026 оны хичээлийн жилд оюутан элсүүлэхэд Монгол Улсын “Дээд боловсролын тухай хууль”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/143 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, 2023 оны Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/97 “Босго оноо тогтоох тухай” тушаал, СЭЗИС-ийн элсэлтийн нэгдсэн бодлого болон энэхүү журмыг баримтална.

1.2 СЭЗИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын бакалаврын хөтөлбөрт Улаанбаатар хот болон орон нутгаас элсүүлэх элсэгчийн хяналтын тоог СЭЗИС-иас тогтооно.

1.3 Элсэлтийн комисс нь СЭЗИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын “Элсэлтийн комиссын ажиллах журам”-ыг мөрдлөг болгон элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, элсэхийг хүсэгчийг бүртгэх, хяналтын тоонд багтаан шалгаруулалт явуулах, ирсэн санал, гомдлыг барагдуулах зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэнэ.

1.4 СЭЗИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын гадаадын иргэнийг элсүүлэх асуудлыг “СЭЗИС-д гадаад иргэнийг суралцуулах журам”-аар зохицуулна.

1.5 Элсэлтийн үйл ажиллагаатай холбоотой элсэлтийн журам, заавар, элсэгчдэд зориулсан цахим зөвлөх үйлчилгээний удирдамж болон холбогдох мэдээллийг СЭЗИС-ийн элсэлтийн системд [/admission.ufe.edu.mn/](http://admission.ufe.edu.mn/) байршуулна.

1.6 Журмын нэр томъёоны тодорхойлолт

- “Элсэлтийн комисс” гэж элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг;
- “Бүртгүүлэгч” гэж СЭЗИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын бакалаврын хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг;
- “Элсэгч” гэж хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулсан бүртгүүлэгчийг;
- “Шилдэг элсэгч” гэж улсын болон олон улсын математик, физик, мэдээлэл зүй, нийгмийн ухаан, түүх, газар зүй, монгол хэл бичиг, гадаад хэлний олимпиадад оролцож медальт байранд орж амжилт гаргасан, урлаг, спортын авьяасаараа манлайлан амжилт гаргасан онцгой авьяас чадвартай бол, СЭЗИС-ийн нэрэмжит олимпиадын шагналт байранд шалгарсан, болон СЭЗИС-ийн элсэлтийн нэгдсэн бодлогын зорилтот бүлгийн элсэгчийг;
- “Олон улсын хэлний шалгуур хангасан элсэгч” гэж гадаад хэлээр олон улсын шалгалт өгч, шалгуур хангасан бүртгүүлэгчийг;
- “Жагсаалт” гэж СЭЗИС-ийн Элсэлтийн комиссоос нийт бүртгүүлэгчийн ЭЕШ-ын оноог эрэмбэлэн мэргэжлийн хөтөлбөр тус бүрээр гаргасан Боловсролын үнэлгээний төв (цаашид БҮТ гэх)-ийн бүртгэлийн дугаар бүхий жагсаалт;

- “Хяналтын тоо” гэж СЭЗИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудад элсүүлэх оюутны тоог;
- “Улсын олимпиад” гэж Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулагддаг үндэсний хэмжээний олимпиадыг;
- “Олон улсын олимпиад” гэж Олон улсын шинж чанартай, ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулагддаг олимпиадыг;
- “Шинэ элсэгчийн тэтгэлэг” гэдэг нь нийгмийн хариуцлагын хүрээнд элсэгчдэд “СЭЗИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудаас холбогдох журмын дагуу олгож байгаа санхүүгийн мөнгөн дэмжлэгийг.
- “Үндсэн хөтөлбөр” гэж өдрийн цагаар 4 жилийн хугацаанд суралцаж мэргэжил эзэмшиж бакалаврын диплом эзэмших хөтөлбөрийг;
- “Олон улсын хамтарсан хөтөлбөр” гэж сургалтын төлөвлөгөөний зарим хэсгийг СЭЗИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудаас, үлдсэн хэсгийг хамтарсан хөтөлбөр олгох сургуульд суралцан нэг мэргэжлээр хоёр сургуулийн диплом олгох хөтөлбөрийг;
- “Элсэлтийн систем” /admission.ufe.edu.mn/ гэдэг нь элсэлтийн үйл ажиллагааг удирдах системийг /мэдээлэл, бүртгэл, онооны эрэмбэ, суралцах эрх, баталгаажилт, цахим төлбөр гэх мэт/;
- “Цахим сургалтын талбар” /online.ufe.edu.mn/ гэдэг нь элсэлтийн үйл ажиллагааг дэмжих цахим талбарыг /мэргэжлийн танилцуулга, цахим зөвлөх үйлчилгээ, ур чадварын шалгалт, сорил өгөх, сургалтын цахим талбар/;
- “Ур чадварын оноо” нь элсэлтийн ерөнхий шалгалтын оноо дээр нэмэгдэх боломжтой тест, ярилцлага хэлбэрээр авагдах элсэлтийн шалгалтын оноог;

Хоёр. Элсэгчдэд тавигдах шаардлага

2.1 СЭЗИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын бакалаврын үндсэн болон олон улсын хамтарсан хөтөлбөрт дараах шаардлагыг хангасан тохиолдолд элсэлтийн бүртгэлд хамрагдана. Үүнд:

1. БҮТ-ийн элсэлтийн ерөнхий шалгалт (цаашид ЭЕШ гэх) өгсөн иргэн;
2. Гадаад улсад ерөнхий боловсрол эзэмшсэн Монгол Улсын болон гадаад иргэн;

2.2 Олон улсын хөтөлбөрийн шалгалтын оноог Монгол Улсын иргэн БШУЯ-ны 2021 оны А/347 тоот тушаалаар баталсан “Олон улсын шалгалт үнэлгээг Монгол Улсын ЭЕШ-ын үнэлгээтэй дүйцүүлэн тооцох тухай журам”-ыг баримтална.

2.3 ЭЕШ-ын “Батламж хуудас” нь шалгалт өгснөөс хойш 2,5 жилийн хүчинтэй. Хоёроос дээш удаа ЭЕШ өгсөн тохиолдолд өндөр оноогоор элсэлтийн шалгуур хангасанд тооцож жагсаалтад оруулна.

2.4 Элсэгч нь ур чадварын шалгалтыг тухайн бүрэлдэхүүн сургуулийн танхимд ирж өгнө.
2.5

Гурав. Элсэлтийн бүртгэл

3.1 Бүрэлдэхүүн сургуулиудын элсэлтийн систем /admission.ufe.edu.mn/-ийн цахим бүртгэл нээгдэн 2025.05.01-ний өдөр эхэлнэ. Бүртгэлийн хураамж 50,000 төгрөг байхаас эрэлттэй мэргэжлээр элсэх Боловсролын сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургуулийн элсэгчдэд 80 хувийн хөнгөлөлт үзүүлнэ. Бүртгүүлэх үйл ажиллагаатай холбоотой зардал гардаг тул бүртгэл цуцлах тохиолдолд хураамж буцааж олгогдохгүй.

3.2 Бүртгүүлэгч элсэлтийн систем /admission.ufe.edu.mn/-д зааврын дагуу шаардлагатай мэдээллээ үнэн зөв оруулж, баталгаажуулна.

3.3 Бүртгэлийн систем /admission.ufe.edu.mn/-д алдаатай мэдээлэл оруулснаас үүсэх асуудлыг СЭЗИС-ийн болон Бүрэлдэхүүн сургуулиудын Элсэлтийн комисс хариуцахгүй.

Дөрөв. Шилдэг элсэгч

4.1 Олон улсын болон үндэсний чанартай олимпиад, уралдаан тэмцээн болон СЭЗИС-ийн нэрэмжит олимпиадад амжилт үзүүлсэн бол тухайн амжилтыг нотлох баримтыг үндэслэн үндэсний босго оноог хангасан тохиолдолд “Шилдэг элсэгч” -ээр шалгаруулж элсүүлнэ.

4.2 “Шилдэг элсэгч”-ээр элсэх хүсэлт гаргахад тавигдах шаардлага:

1. Улсын болон олон улсын математикийн олимпиадад медальт байрт шалгарсан бол;
2. Монгол хэл бичиг, нийгмийн ухаан, түүх, газар зүй, гадаад хэлний олимпиадад медальт байрт шалгарсан;
3. Урлаг, спорт чиглэлээр олон улсын болон улсын тэмцээнд медальт болон шагналт байрт шалгарч байсан онцгой авьяас чадвартай;
4. Кембрижийн болон олон улсын AS (A) түвшний шалгалтын B (70)-ээс дээш оноотой бүртгүүлэгч, IB олон улсын 24-45 оноотой;
5. СЭЗИС-ийн нэрэмжит “Математик, Англи хэл”, “Нийгмийн тухай мэдлэг” олимпиадын шагналт байр эзэлсэн;

Тав. Олон улсын хэлний шалгуур хангасан элсэгч

5.1 Олон улсын шалгалтын амжилтыг нотлох баримтыг үндэслэн үндэсний босго онооны болзол хангасан тохиолдолд “Олон улсын хэлний шалгуур хангасан элсэгч”-ийг хамтарсан болон үндсэн хөтөлбөрт элсүүлнэ.

5.2 “Олон улсын хэлний шалгуур хангасан элсэгч”-ээр элсэх хүсэлт гаргахад тавигдах шаардлага:

1. Англи хэлний олон улсын шалгалтын IELTS 6, TOEFL iBT80, TOEFL ITP550, хятад хэлний HSK шалгалтын 4-р зэрэгтэй элсэгчийг олон улсын хамтарсан хөтөлбөрт Хавсралт №01-т зааснаар суралцах хэлбэрийг сонгуулан элсүүлнэ.

Зургаа. Элсэлтийн шалгаруулалт

6.1 СЭЗИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын бакалаврын үндсэн болон олон улсын хамтарсан хөтөлбөрт элсэгчийг дараах үе шаттайгаар шалгаруулна. Үүнд:

1. Бүртгэл орон даяар цахим хэлбэрээр зохион байгуулагдах;
2. Бүлэг тус бүрээр шалгуур хангасан элсэгчдийн онооны жагсаалт гаргах;
3. Сургалтын урьдчилгаа төлбөр төлөх;

4. Суралцах мэргэжил, хөтөлбөрөө хяналтын тоонд багтаан баталгаажуулах;
5. Суралцах болзол хангасан элсэгчдэд мэдэгдэх;
6. Дэлгэрэнгүй анкет бөглөх;
7. Суралцах эрхийн бичиг, сургалтын гэрээний нөхцөлийг цахим шуудангаар хүлээн авах;

6.2 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 09:00 цагаас бүлэг тус бүрээр жагсаалтыг гарган, орон даяар элсэлтийн системээр /admission.ufe.edu.mn/ хаягаар зарлана.

6.3 Бүртгүүлэгч эрхээрээ элсэлтийн систем /admission.ufe.edu.mn/-д нэвтрэн элсэлтийн өөрийн төлөвтэй танилцана. Тэнцсэн, хүлээгдэж буй, тэнцээгүй гэсэн төлөвтэй байна.

- 6.4 Онооны жагсаалтыг ЭЕШ-1, ЭЕШ-2 тус бүрийн аль нэг (хамгийн өндөр оноотой хичээлээр нь авна) оноо болон ур чадварын шалгалтын онооны эрэмбээр гаргана.
- 6.5 Нэг элсэгч хэд хэдэн бүлгийн жагсаалтад орж болно.
- 6.6 Хугацаандаа баталгаажуулалт хийгээгүй тохиолдолд дараагийн бүртгүүлэгчид сонголт хийх эрх шилжих ба үүнээс үүдэх хариуцлагыг бүртгүүлэгч бүрэн хариуцна.
- 6.7 Суралцах мэргэжил, хөтөлбөрийг ЭЕШ-ын дүн гарснаас хойш 1 өдрийн дараа СЭЗИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн элсэлтийн цахим системээр баталгаажуулж, “Суралцах эрхийн бичиг”-ийг элсэгчийн и-мэйл хаягаар олгоно.

Долоо. Тэтгэлэг

- 7.1 СЭЗИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын нийгмийн хариуцлагын хүрээнд сурах боломж олгох шинэ элсэгчийн тэтгэлгийг “СЭЗИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын шинэ элсэгчид тэтгэлэг олгох журам”-аар зохицуулна.
- 7.2 СЭЗИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын босго оноог бүрэн хангасан, суралцах чин хүсэл эрмэлзэлтэй, амжилттай суралцаж байгаа элсэгчид сургалтын төлбөрийн тодорхой хувийн тэтгэлэг олгоно.
- 7.3 Шинэ элсэгчийн тэтгэлэгт хамрагдсан элсэгчдэд олгох мөнгөн дүнг 2025-2026 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрт оруулж тооцно.

Найм. Бусад


1. Элсэлттэй холбоотой аливаа санал, хүсэлтийг СЭЗИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн элсэлтийн комисст гарган, ажлын 3 өдөрт шийдвэрлэнэ.

ХАВСРАЛТ №02. ЭЛСЭГЧДЭД ТАВИХ ШАЛГУУР



№	Мэргэжлийн хөтөлбөр	Д/д	Суралцах хэлбэр (хугацаа)	Бүлэг - элсэлтийн шалгуур
СЭЗИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургууль Бүлэг I				
1	Дижитал архив, өгөгдлийн сангийн мэргэжилтэн	1.1	Үндсэн хөтөлбөр (4 жил СЭЗИС-ийн НШУС)	ЭЕШ-1 Монгол хэл, түүх хичээлийн аль нэг 490+ ЭЕШ-2 Нийгмийн тухай мэдлэг, Математик 450+
2	Төрийн удирдлага	2.1	Үндсэн хөтөлбөр (4 жил СЭЗИС-ийн НШУС)	ЭЕШ 1- Нийгмийн тухай мэдлэг, Математик хичээлийн аль нэг 490+ ЭЕШ2-Англи хэл, Монгол хэл хичээлийн аль нэг нь 490+
СЭЗИС-ийн Инженер, Технологийн сургууль Бүлэг II				
3	График дизайн	3.1	Үндсэн хөтөлбөр (4 жил СЭЗИС-ийн ИТС)	ЭЕШ -1 Математик, Англи хэл аль нэг нь 450+ ЭЕШ-2 Ур чадвар 490+
	График дизайн /Visual art/	3.2	Үндсэн хөтөлбөр (2 жил СЭЗИС-ийн ИТС) Тайваны Nanhua University 2 жил	ЭЕШ -1 Математик, Англи хэл аль нэг нь 450+ ЭЕШ-2 Ур чадвар 490+
4	Онлайн худалдаа		Үндсэн хөтөлбөр (4 жил СЭЗИС-ийн ИТС)	ЭЕШ -1 Математик 490+ ЭЕШ-2 Англи хэл 490+
5	Программ хангамж		Үндсэн хөтөлбөр (4 жил СЭЗИС-ийн ИТС)	ЭЕШ -1 Математик 490+ ЭЕШ-2 Англи хэл 490+
6	Мэдээллийн аюулгүй байдал		Үндсэн хөтөлбөр (4 жил СЭЗИС-ийн ИТС)	ЭЕШ -1 Математик 490+ ЭЕШ-2 Англи хэл 490+
7	Хиймэл оюун ухаан		Үндсэн хөтөлбөр (4 жил СЭЗИС-ийн ИТС)	ЭЕШ -1 Математик 490+ ЭЕШ-2 Англи хэл 490+
8	Сэтгэл судлал		Үндсэн хөтөлбөр (4 жил СЭЗИС-ийн ИТС)	ЭЕШ -1 Нийгэм судлал, Математик аль нэг нь 490+ ЭЕШ-2 Монгол хэл, Англи хэл аль нэг нь 490+
СЭЗИС-ийн Боловсролын сургууль Бүлэг III				
1	Багш, сургуулийн өмнөх боловсрол	1.1	Үндсэн хөтөлбөр (4 жил СЭЗИС-ийн БС)	ЭЕШ 1- Монгол хэл, Нийгмийн тухай мэдлэг хичээлийн аль нэг 440+ ЭЕШ2- Ур чадвар 490+
	Багш, сургуулийн өмнөх боловсрол 2+2	2.2	Үндсэн хөтөлбөрт 2 жил + Японы Кансай Их сургуульд 2 жил	ЭЕШ 1- Монгол хэл, Нийгмийн тухай мэдлэг хичээлийн аль нэг 440+

				ЭЕШ2- Ур чадвар 490 +
2	Багш, бага боловсрол	2.1	Үндсэн хөтөлбөр (4 жил СЭЗИС-ийн БС)	ЭЕШ 1- Монгол хэл, математик хичээлийн аль нэг 450+ ЭЕШ2- Ур чадвар 490+
3	Багш, монгол хэл-уран зохиолын боловсрол	3.1	Үндсэн хөтөлбөр (4 жил СЭЗИС-ийн БС)	ЭЕШ 1- Монгол хэл 490+ ЭЕШ 2 Ур чадварын шалгалт 490+
4	Багш, мэдээлэл зүйн боловсрол	4.1	Үндсэн хөтөлбөр (4 жил СЭЗИС-ийн БС)	ЭЕШ 1- Математик 490+ ЭЕШ2- Ур чадвар 490+
5	Багш, математикийн боловсрол	5.1	Үндсэн хөтөлбөр (4 жил СЭЗИС-ийн БС)	ЭЕШ 1- Математик, Физик хичээлийн аль нэг нь 490+ ЭЕШ 2- Ур чадварын шалгалт 490+
6	Багш, гадаад хэлний боловсрол	6.1	Үндсэн хөтөлбөр (4 жил СЭЗИС-ийн БС)	ЭЕШ 1- Англи хэл, Орос хэл хичээлийн аль нэг нь 490+ ЭЕШ 2- Ур чадварын шалгалт 490+



СЭЗИС-ийн Бүрэлдэхүүн Сургуулиудын Шинэ Элсэгчид Тэтгэлэг Олгох Журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Шинэ элсэгчийн тэтгэлэг нь СЭЗИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудад амжилттай суралцах хүсэл эрмэлзэлтэй оюутанд сургалтын төлбөрийн дэмжлэг олгох, амжилттай суралцах идэвх, урам зоригийг нэмэгдүүлэх зорилготой.

1.2 Энэхүү журам нь тэтгэлэг хүсэгчдэд тавигдах шаардлагыг тодорхойлох, тэтгэлэг хүсэгчийн хүсэлт гаргах, шалгаруулалт хийх, элсэгчдэд тэтгэлэг олгох үйл ажиллагааг зохицуулна.

1.3 Шинэ элсэгчийн тэтгэлэг гэдэг нь үндэсний хэмжээний босго оноог хөтөлбөр тус бүрээр хангасан элсэгчдэд олгож байгаа нэг удаагийн сургалтын төлбөрийн хөнгөлөлтийг;

1.4 "Тэтгэлэг горилогч" гэж энэхүү журмын 2-р зүйлийн шалгуурыг хангасан элсэгчийг хэлнэ.

1.5 "Тэтгэлгийн комисс" гэж элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар СЭЗИС-ийн Ректорын тушаалаар томилогдсон ажлын хэсгийг хэлнэ.

Хоёр. Тэтгэлгийн шалгуур, бүрдүүлэх материал

2.1 Тэтгэлгийн шалгуур: Тухайн хөтөлбөрийн ЕЭШ-ын босго оноог хангасан байх

2.2 Бүрэлдэхүүн сургуулиудын хөтөлбөрүүдийн босго оноог хангасан, бүлэг тус бүрээр шалгуур хангасан элсэгч дараах байдлаар эхний жилийн сургалтын төлбөрөөс шинэ элсэгчийн тэтгэлгийн дэмжлэгийг үзүүлнэ. Сургалтын төлбөрөөс хөтөлбөр тус бүрээр эхний жил үзүүлэх тэтгэлгийн хувь, хэмжээ. Үүнд:

Д/д	Хөтөлбөрийн нэр	2025-2026 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх шинэ элсэгчийн тэтгэлгийн хувь, хэмжээ
СЭЗИС-ийн Боловсролын сургууль		
1	Багш, сургуулийн өмнөх боловсрол	55%
2	Багш, бага боловсрол	55%
3	Багш, монгол хэл-уран зохиолын боловсрол	55%
4	Багш, математикийн боловсрол	55%
5	Багш, мэдээлэл зүйн боловсрол	55%
СЭЗИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургууль		
6	Дижитал архив, өгөгдлийн сангийн мэргэжилтэн	55%
7	Төрийн удирдлага	55%

2.3 Бүрдүүлэх материал

Бүрэлдэхүүн сургуулиудад элсэх үндэсний хэмжээний босго оноог хангаж, Боловсролын сургууль, НШУС-аас суралцах эрхээ авсан үндсэн болон хамтарсан хөтөлбөрийн элсэгч бүр шинэ элсэгчийн тэтгэлэгт хамрагдана. Тиймээс материал бүрдүүлэх шаардлагагүй

Гурав. Бусад

3.1 Энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмаар зохицуулна.

